

# ЭДИЙН ЗАСГИЙН ГУРВАЛЖИН

Г. Гунгаа

Дэлхий дахинд улс орнуудын үйлдвэржих ялц түргэсч, бүтээгдэхүүний нэр төрөл олширч, аж ахуй нь тавааржиж, эдийн засгийн үр нөлөө улам бүр зонхилох байдалтай болохын зэрэгцээгээр хүн ам өсч, нөөц баялаг хомсдож, эрэлт хэрэгцээ улам ихэсч байгаа учраас улс орон, бүс нутаг, үйлдвэр аж ахуйн газрууд чөлөөт зах зээлээр дамжуулан байгаагаараа байхгүйгээ, илүү гарсан зүйлээрээ дутуугаа нөхөж байдаг арилжаа наймааны энгийн хэлбэрнийг хөгжүүлэх явдал зүй ёсоор шаардаж байна.

Дэлхийн улс орнуудын худалдаа эдийн засгийн хөгжлийн чиг хандлага олон талтай, олон төвтэй, олон салбартай, олон түнштэй, олон зах зээлтэй байх нь нэг улс, нэг тив, нэг бүс нутгийн хүрээнд хязгаарлагдмал байдалд байснаасаа давуутай болох нь амьдралд нэгэнт батлагддаг байгаа болохоор улс хоорондын том жижиг янз бүрийн нийгэмлэг, эвсэл холбоод байгуулагдаж байна.

Гэвч орчин үед европын хамтны нийгэмлэг, Зүүн өмнөд азийн холбоо зэрэг нь хэдийгээр бүс нутгийн эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл, эрүүлийг хамгаалах зэрэг бүх салбарыг хөгжүүлэх чиглэлтэй боловч хамаарагдах газар нутаг өргөн уулам, оролцогч улс орон олон учраас соёл шинжлэх ухааны нээлт бүтээлийг нэлтрүүлэх, үйлдвэр аж ахуйн газрын ололт туршлагыг дэлгэрүүлэх, бүх төрлийн мэдээлэл солилцоход цаг хугацаа алдах, харилцаа холбооны бэрхшээл, зам тээврийн хүндрэл зэргээс болж нийтлэг шинж чанарыг тэр бүр хангаж чадахгүй байгаа болохоор хөрш зэргэлдээ улс орон, бүс нутгийн шинжтэй гурвалсан холбоо байгуулах нь илүү ашигтай юм гэдэг ойлголт нэгэнт бий болсон улам нийтлэг шинжтэй болж байна. Тухайлбал:

Ази-Австрали-Америк тивийн гурвалжин, Япон-Америк-Америк тив /Америк улсаас бусад/-ийн гурвалжин, Америк-Канад-Мексикийн гурвалжин, Хятад-Гонконг-Тайваны гурвалжин, Хятад-Япон-Оросын гурвалжин, Америк-Япон-Зүүн өмнөд азийн гурвалжин, Япон-Азийн дөрвөн бар-Зүүн Азийн гурвалжин зэрэг тив, улс хоорондын шинжтэй холбоонууд байгуулагдаад ажиллаж байна.

Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хүрээнд доорхи "гурвалсан холбоо"-нууд бий болоод улс орнуудын олон талын хамтын ажиллагаанд улам тодорхой үүрэгтэй болж байна. Үүнт:

1. Сингапур-Жохор бару /малайзын/-Никобар /Индонезийн/-аас бүрдсэн гурвалжны холбоо

2. Пхукет /Тайландын/-Пинонг /Малайзын/-Суматр /Индонезийн/-ын гурвалжны холбоо

3. Телон ансан /Малайзын/-Калимантан /Индонезийн/-Филиппинээс

Г. Гунгаа-Зүүн хойг Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан

бүрдсэн гурвалжны холбоо зэрэг болно.

Эүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засгийн хүрээнд Түмэн голын адагт оршдог Хятад-Орос-Солонгос гурван улсын чөлөөт худалдааны бүс хамтран нээх тухай төсөл нь олны анхаарлыг ихээхэн татаж байна.

Үүнд:

1. Хунь чунь /Хятадын/-Посьет /Оросын/-Ражин /Солонгосын/-аас бүрдсэн "Бага гурвалжны холбоо".

2. Чан чунь /Хятадын/-Владивосток /Оросын/-Чхан жин /Солонгосын/-ээс бүрдсэн "Их гурвалжны холбоо" зэрэг эдийн засгийн нээлттэй бүс байгуулах санаачилга бий болоод хэрэгжих төлөвтэй байна.

Манай улс эх газрын ядуу эдийн засагтай өвөрмөц жижиг орон мөн боловч далайд нэвтрэх гарцтай болох, гадаад ертөнцтэй харилцах, гадаад зах зээлийн хүрээг өргөтгөх нь манай орныг эдийн засгийн хямралт байдлаас гарах болон эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хувьд зогсонги байдлаасаа ангижрахад үр өгөөжтэй нь ойлгомжтой юм.

Гэвч дээрх гурвалжнуудын аль аль нь газар зүйн байршлын хувьд алс хол оршдог учраас агаарын тээвэр хөгжөөгүй манай орны хувьд шууд харилцах боломж муутай юм.

Үүний дотроос манай улсад арай ойр дөт гэж үзэж болохуйц хоёр зам байгаа бөгөөд үүнийг тус бүрд нь авч үзвэл:

1. Улаанбаатар-Чойбалсан-Эрэн цав-Борж-Манжуур-Харбин-Владивосток /2400 гаран км/-ын чиглэл.

2. Улаанбаатар-Замын үүд-Бээжин-Тянь жинь /1400 гаран км/-ын чиглэл юм.

Манай улс биеэ дааж агаарын тээвэр хийх бололцоотой бол Австрали, Шинэ Зеланд зэрэг адил төстэй аж ахуй эрхэлдэг улс орнуудтай ч шууд харилцаж болох юм.

Гэтэл биеэ дааж агаарын тээвэр хийх бололцоогүй байгаа өнөө үед дээрх хоёр чиглэлээр далайд нэвтрэх гарцтай болж, улмаар Ази, Номхон далайн улс орнууд ба бүс нутгийн чанартай гурвалжны холбоотой харилцаж чадвал эдийн засгийн хувьд эрх биш үр өгөөжтэй болно гэж үзэж байна.